

БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

НЭГ. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр

- 1.1. Удирдлага зохион байгуулалтын талаар..... 2
- 1.2. Байгууллагын хүний нөөцийн талаар 2
- 1.3. Албан хаагчдыг удирдлага арга зүйгээр хангах 3-4
- 1.4. Хяналт шалгалтын чиглэлээр4-5
- 1.5. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр7-10
- 1.6. Хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн улсын
бүртгэлийн чиглэлээр11-14
- 1.7. Санхүүгийн чиглэлээр14-15
- 1.8. Архивын үйл ажиллагааны чиглэлээр16-18
- 1.9. Мэдээлэл технологийн чиглэлээр18-19

ХОЁР. Орон нутгийн удирдлага, бусад байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр 20-24

ГУРАВ. Идэвх санаачилга, шинэлэг ажлын талаар 24-27

ДӨРӨВ. “Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд27-28

ТАВ. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд29-30



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

1.1. Удирдлага зохион байгуулалтын талаар

Булган аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэл хөтлөхтэй холбогдсон нийтлэг харилцааг зохицуулан бүртгэлийн үнэн зөв байдлыг ханган 2024 оны жилийн эцсийн байдлаар 29 албан хаагчтайгаар иргэний улсын бүртгэл, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр Булган аймгийн 1 тосгон 16 сумын хүрээнд үйл ажиллагаагаа эрхлэн явуулж байна.

Тус хэлтэст 2024 оны 11 сарын 21-ний өдрийн байдлаар нийт ирсэн албан бичиг 722, үүнээс хариутай 360 албан бичгийн 357 албан бичгийг хугацаанд нь хүргүүлж, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 3 албан бичиг байна. Бусад газар хүргүүлсэн албан бичиг 627, мөн өргөдөл гомдол нийт 41 бүртгэгдсэнээс 40 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүлэн ажилласан бол 1 өргөдлийн хуулийн хугацаа болоогүй шалгагдаж байна. Хэлтсийн даргын А тушаал 27, Б тушаал 5 гарсан бөгөөд тушаалын хэрэгжилтэд хэлтсийн дарга болон холбогдох албан хаагч тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Хэлтсийн үнэт цаас, бараа материалыг тоо бүртгэлээр хөтөлж, хадгаламж үүсгэн сар бүрийн 5-ны өдрийн дотор албан хаагчдын үнэт цаасны тайланг нэгтгэж УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст Edoc-оор болон ts.ganchimeg@burtgel.gov.mn хаягаар хүргүүлж хэвшсэн.

1.2. Байгууллагын хүний нөөцийн талаар

2024 оны эхний хагас жилийн байдлаар УБЕГ-аас тус хэлтэст холбогдуулан ирүүлсэн 39 тушаал байгаагаас А тушаал 15, Б тушаал 24 ирсэн байна. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн хэрэгжилтийг ханган өмнө онд хэлтсийн 8 албан хаагч ҮТИСургуулийг “Эрх зүйч” мэргэжил эзэмшиж амжилттай төгссөн бөгөөд 2024.01.01-ны өдрөөс Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Э.Нандинцэцэгийг Хэлтсийн хяналтын улсын байцаагчаар, 2024.03.01-2024.05.01-ны өдрийг хүртэлх хугацаанд гэрээт ажилтан Б.Ганбаярыг иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчээр, хүүхэд асрах чөлөөг дуусгавар болгож 2024.05.01-ны өдрөөс Д.Мөнхцэцэгийг иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчээр, 2024.01.29-ны өдрөөс Б.Одончимэгийг, 2024.03.01-ны өдрөөс Н.Билгүүн нарыг Хуулийн этгээд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчээр, Хуулийн этгээдийн улсын бүртгэгч А.Раднаабаярыг Рашаант сумын иргэний улсын бүртгэгчээр, 2024.11.01-ны өдрөөс Тэшиг сумын улсын бүртгэгч Г.Саруул нь Орхон аймгийн улсын бүртгэгчээр шилжин ажиллаж, Хэлтсийн хуулийн этгээдийн улсын бүртгэгчийн сул орон тоог нөхөх шалгалтыг журмын дагуу зарлуулж хүний нөөцийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1.3. Албан хаагчдыг удирдлага арга зүйгээр хангах ажлын хүрээнд

Улсын бүртгэлийн байгууллагын нийт ажилтан албан хаагчдыг хамруулсан НЭГДСЭН сургалтын төлөвлөгөөг доорх байдлаар гарган хэрэгжилтийг ханган ажилласан бөгөөд төлөвлөгөөний дагуу 2024.05.07-ны өдөр 16 сум 1 тосгоны улсын бүртгэгч, хэлтсийн албан хаагчдыг хамруулсан нэгдсэн арга зүйгээр хангах сургалтыг танхимаар зохион байгуулсан. Үүнд:

- ✓ Зохион байгуулагч: Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс
- ✓ Зохион байгуулах газар: Булган сумын ЗДТГ-ын иргэдийн хурлын танхим
- ✓ Зохион байгуулах огноо: 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр

Уг арга хэмжээнд Булган аймгийн ЗДТГ-ын дарга хүрэлцэн ирж сонгуулийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар болон анхаарах асуудлуудын талаар мэдээлэл хүргэж, албан үүрэгтээ хариуцлагатай үр бүтээлтэй ажиллаж байгаа хэлтсийн архивч Б.Байгалмаа нь Хууль зүйн албаны “ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН” хүндэт тэмдэгээр, Иргэний бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч Г.Ганчимэг, Хяналтын улсын байцаагч Э.Нандинцэцэг нар Хууль зүй дотоод хэргийн яамны “Хүндэт жуух бичиг”-ээр шагнагдсан.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Дээрх арга хэмжээнд хяналтын улсын байцаагч нь **“Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, анхаарах асуудлууд”** сэдвээр сургалт зохион байгуулж, албан хаагчдад мэдээлэл хүргэж ажилласан.



2024.01.31-нд
мэргэжилтэн
М.Дэлгэрмаа



**"МЭРГЭЖЛИЙН ХАРИЛЦАА-
ХАНДЛАГА, ТӨРИЙН АЛБАН
ХААГЧИЙН ЁС ЗҮЙ"** сэдэвт
сургалт зохион байгуулагдав



2024.03.14-нд Хяналтын
прокурор, хууль цаазын
итгэмжит зөвлөх
Ц.Сувдаа



**"ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ"** сэдэвт
сургалт зохион байгуулагдав



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



2024.03.22-нд
ЗДТГ-ын Хууль эрх зүйн
сургалтын баг

"НЭХЭМЖЛЭЛ, ТҮҮНИЙ
БҮРДҮҮЛБЭР", "ГЭР БҮЛИЙН
ХАРИЛЦАА" сэдэвт сургалт
зохион байгуулагдав

Албан хаагчдыг удирдлага арга зүйгээр хангах ажлын хүрээнд Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг дэмжих зорилгоор Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагдаж буй 7/4/10-ын нийт 20 удаагийн цахим сургалтад улсын бүртгэгч нарыг бүрэн хамруулж, Булган аймгаас зохион байгуулагдсан 4 удаагийн сургалтанд 30 албан хаагч, дотооддоо зохион байгуулсан 2 удаагийн танхим, 16 удаагийн цахим сургалтад нийт 25 албан хаагч, иргэн-төрийн байгууллага руу чиглэсэн сургалтад 63 гаруй иргэн, албан хаагчдад мэдээлэл хүргэж ажилласан байна.

1.4. Хяналт шалгалтын чиглэлээр

Булган аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн 2023 оны улсын бүртгэл хөтлөх болон түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг шалгаж, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилган, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулах зорилгоор 2024 оны 02 дугаар сард урьдчилсан хяналт шалгалтын удирдамжыг гарган, хяналт шалгалтын төлөвлөгөө боловсруулж батлуулсаны дагуу Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн 2023 оны 996 бүртгэлд, Иргэний улсын бүртгэлд 2023 онд бүртгүүлсэн 84 бүртгэлд, Хуулийн этгээдийн 93 бүртгэлд нийт **1362** бүртгэлд хяналт шалгалт хийж 167 зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажилласан.

2024 оны бүртгэлийн үйл ажиллагаанд нийт 1572 хяналт шалгалт хийж гүйцэтгэн 228 бүртгэлийн зөрчил илрүүлэн зөрчлийг арилгуулсан байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналт шалгалтын газрын даргаас ирүүлсэн 2024 оны 6/4865, Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны 6/9869 дугаартай



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

албан бичгээр ирүүлсэн хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлж шуурхай хэрэг зөрчлийг таслан зогсоох, бүртгэлийг хуульд нийцүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тус хэлтсийн иргэний улсын бүртгэлд 2024.01.02-2024.08.12-ны өдрийг хүртэлх хугацаанд бүртгэгдсэн **756** шилжилт хөдөлгөөний бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд тусгагдсан мэдээллийг эх нотлох баримт бичигтэй тулган нягталж, Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журмын 10.3, 10.4-т заасны дагуу шилжилт хөдөлгөөний ИУБ—22 маягтын баруун дээд өнцөгт хянасан тухай тэмдэглэгээг хийж, тэмдэг дарж баталгаажуулж ажилласан бөгөөд илтгэх хуудсыг хүргүүлж ажилласан.



✓ Тайлант хугацаанд бүртгэлтэй холбогдуулан ирүүлсэн 90 өргөдөл гомдлыг хүлээн авч архивын эх нотлох баримттай тулган шалгаж хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарган бүрэн шийдвэрлэсэн.

Дүгнэлтийг авч үзвэл:

Иргэний бүртгэлийн чиглэлээр - 39

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр – 45

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр – 2;

✓ Хяналт шалгалтын зөрчлийн нэгдсэн санд бүртгэлтэй шүүхээр хянан шийдвэрлэгдэж буй хэрэг маргааны **11** бүртгэл үүсгэсэн байх бөгөөд тайлант хугацаанд нийт **3** хэрэг маргааныг санд тусгаж баталгаажуулсан бөгөөд шүүхийн шатанд явж буй шийдвэрлэгдээгүй гэх **3** хэрэг бүртгэл байна.

✓ Захиргааны зөрчил гаргасан этгээдэд зөрчлийн тухай хуулийн дагуу хялбаршуулсан журмаар **363** иргэний зөрчлийг шалган шийдвэрлэж 9.155.0 /есөн сая нэг зуун тавин таван мянга/ төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэн ажилласан. Зөрчлийн шийдвэрлэлтийг задлан харуулвал:

Торгууль оногдуулсан хүн – 357

Торгууль оногдуулсан хуулийн этгээд – 2

Зөрчлийн хэрэг нээсэн төрийн байгууллага - 4 байна.

✓ Тус хэлтсийн хяналтын улсын байцаагч нь 3 дугаар улирлын байдлаар зөрчил шалган шийдвэрлэсэн нийт зөрчлийн хэрэг материалыг Булган аймгийн прокурорын газрын хяналтын прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Ц.Сувдаад бүрэн хянуулж, бүртгэлийн дэвтэрт хянасан тухай тэмдэглэл үйлдүүлэн холбогдох арга хэмжээг авч, “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг бий болгох ажлын хүрээнд хийгдэж буй урьдчилан бэлтгэл хангах ажлыг зохион байгуулж түүнтэй



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

холбогдуулан авч хэрэгжүүлсэн ажлын тайланг Булган аймгийн Прокурорын газарт хүргүүлэн Булган аймгийн Шалган шийдвэрлэх байгууллагын Хамтарсан зөвлөгөөн 2024.05.09-ны өдөр зохион байгуулагдаж уг арга хэмжээнд хамтран оролцлоо.

✓ Булган аймгийн прокурорын газраас 2023 онд тус аймгийн хэмжээнд үйлдэгдэн гарсан зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж, дүн шинжилгээ хийхэд манай байгууллагын нэр бүхий 1 албан хаагчаас Зөрчлийн тухай хуулийг зөрчиж, шийтгэл хүлээж, албадлагын арга хэмжээ авагдсан ажлын хүрээнд Аймгийн прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөхийн ирүүлсэн 01 дугаартай мэдэгдлийн мөрөөр зөрчил гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцөлийг арилгах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд доорх арга хэмжээг авч ажилласан болно.

✓ Үүнд:

Цаашид дээрх төрлийн зөрчил давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан зарим чиг үүргээ хэрэгжүүлж зөрчил үйлдсэн улсын бүртгэгч А.Раднаабаярын зан, үйл, дадал, гэмт хэрэг, зөрчлийг өдөөж болзошгүй шалтгаан, нөхцөлийг тогтоохоор албан хаагчтай ганцаарчилсан уулзалтыг хийж, цаашид дахин давтан үйлдэхгүй байхад анхаарч ажиллахыг үүрэг болгож, Хэрэв дээрх төрлийн гэмт хэрэг дахин үйлдэгдвэл холбогдох хуулийн хариуцлага хүлээх болохоо гэрчилсэн баталгааны хуудас гаргуулан авсан.



1.5. Иргэний бүртгэлийн чиглэлээр:

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын ирүүлсэн 2024.07.01-ний 3/8816 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлсэн Хяналтын улсын ахлах байцаагч А.Мөнхцэцэгийн 2024.06.26-ны өдрийн 38 дугаартай шаардлагыг хүлээн авч доорх арга хэмжээг авч ажиллалаа. 2024.07.02-ны өдрийн 16⁰⁰ минутад цахим хурал зарлаж 16 сум 1 тосгоны Улсын бүртгэгч нарыг 100% хамруулан, хэлтсийн албан хаагчдад танхимаар дээрх албан бичиг болон хавсралтаар ирүүлсэн мэдэгдлийг танилцуулж аливаа эрсдэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээллийг хүргэсэн. Цаашид өдөр тутмын ажил үйлчилгээнд тогтмол хурууны хээгээр үйлчилгээ үзүүлж байх, хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу бусдын мэдээллийг албан бус байдлаар дамжуулахгүй байх талаар онцгойлон анхаарууллаа. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр бүртгэсэн бүртгэлд байнгын хяналт тавин ажиллалаа.

ИУБГ-аас нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд дүн шинжилгээ хийж нийтлэг гарч буй алдаа зөрчил, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2024.10.01-ний өдөр зохион байгуулсан сургалтад 2024.11.01-ний өдөр хууль журмын шинэчилэл, иргэний улсын бүртгэлийн талаар, иргэний улсын бүртгэлийг цахимаар хөтлөх, нэмэлт өөрчлөлт, нөхөн бүртгэлийн чиглэлээр зохион байгуулсан цахим сургалт, 2024.08.23-ны өдөр ИУБГ-аас улсын бүртгэгч нарыг бүртгэлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулсан тоон гарын үсэг олголт, нэмэлт өөрчлөлтийн бүртгэлийн талаарх сургалтад улсын ахлах бүртгэгч хамрагдаж энэ



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

талаарх сургалтыг нийт улсын бүртгэгч нарт тухай зохион байгуулж мэргэжил арга зүйгээр тогтмол ханган ажилласан.

Сонгуулийн тухай хуулийн дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогссонтой холбогдуулан шилжин ирсэн иргэдийн тоон мэдээг өмнөх онуудын мөн үетэй харьцуулан видео мэдээ бэлтгэн хэлтсийн цахим хуудас болон пэйсбүүк, пэйж хуудаст байршууллаа. Мөн сонгуулийн тухай хуулийн дагуу цахим хуудаст байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалттай хэрхэн танилцах талаар видео контент бэлтгэн хэлтсийн цахим хуудас болон пэйсбүүк, пэйж хуудаст байршуулсан.

Мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд:

Улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, үнэлэлт дүгнэлт өгөх ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нас баралтын бүртгэл нэгээс дээш бүртгэгдсэн 95 иргэний 190 бичилтийг архивын эх нотлох баримт буюу цаасан болон цахим архивын материалтай тулган нягтлан шалгах ажлыг хийж гүйцэтгэсэн. Дээрх иргэдийн мэдээллийг шалгах явцад 35 иргэний бүртгэл мэдээллийн санд давхар орсон, 60 иргэний бүртгэл 2 өөр бүртгэлийн нэгжид давхар бүртгэгдсэн зөрчилтэй байна. Уг зөрчлийг шийдвэрлүүлэхээр Хэлтсийн Хяналтын улсын байцаагчид шилжүүлж ХУБ-ийн 2024.01.25-ны №331 дугаартай “Бүртгэл хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах тухай” дүгнэлт гаргуулан 2024.01.26-ны өдрийн №46 тоот албан бичгээр Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлж хүчингүй болгосон. Мэдээллийн санд нэг хаягт бүртгэлтэй үндсэн мэдээлэл ижил 6 иргэний бүртгэлийг шалгаж 3 иргэний төрөлтийн бүртгэлийг ХУБ-ын дүгнэлтээр хүчингүй болгосон. Мэдээллийн санд өөр хаягт бүртгэлтэй үндсэн мэдээлэл ижил 126 иргэний мэдээллийг шалгаж 14 иргэний төрөлтийн бүртгэл болон регистрийн дугаарын бүртгэлийг хүчингүй болгосон. ИУБГ-аас 2024.10.21-ны өдөр мэдээллийн санд 2 ба түүнээс дээш бүртгэгдсэн 4 иргэний нас баралтын бүртгэлийн жагсаалтыг ирүүлсний дагуу шалгаж ХУБ-ын дүгнэлт гаргуулан хүчингүй болгосон. Мөн энэ ажлын хүрээнд мэдээллийн санд ургийн овог болон гэрлэлтийн төлөв буруу, төрөлтийн бүртгэлд эцэг, эхийн мэдээлэл тусаагүй зэрэг 260 бүртгэлд нэмэлт өөрчлөлт оруулан иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд нийт 474 бүртгэлийг цэгцэлсэн байна.

Тоон гарын үсэг олголтын талаар:

Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх зорилгоор улсын бүртгэлийн байгууллагын зөөврийн төхөөрөмжийг ашиглан 2024.05.20-ны өдөр Баян-Агт сумын 5-р багт, 2024.05.28-ны өдөр Хутаг-Өндөр сумын 1-р багийн иргэдэд тоон гарын үсэг олгох ажлыг зохион байгуулан 60 гаруй иргэнд тоон гарын үсэг олголоо. Мөн 2024.05.09-ны өдөр Булган аймгийн төв талбайд “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулж 50 гаруй иргэнд тоон гарын үсэг олгож ажилласан.

Төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэйгээр хүргэх зорилгоор улсын бүртгэлийн зөөврийн төхөөрөмжийг ашиглан Булган сумын “Эрдмийн өргөө” цогцолбор сургуульд очиж 16 нас хүрсэн 4 иргэнд иргэний үнэмлэхийн бүртгэл, 22 иргэнд тоон гарын үсгийн үйлчилгээ үзүүлээ. 2024.11.20-ны өдрийн байдлаар нийт 22300 иргэнд тоон гарын үсэг олгоод байна



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Сонгуулийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар тус хэлтсийн хэрэгжүүлэх дэд төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг ханган ажиллалаа. Төлөвлөгөөний дагуу Сумын ИТХ-ын хэсэг байгуулсан тогтоолуудыг хүлээн авч нягтлан шалгаж сонгогчийн бүртгэлийн програмд бүртгэн хуулийн хугацаанд УБЕГ-т хүргүүлсэн. Сонгуулийн хэсэгт оноогдсон сонгогчдын мэдээллийг нягтлан шалгаж хэсэгт оноогдоогүй сонгогчид тухай бүр хэсэг оноож нягтлан шаглгасан тухай илтгэх хуудсыг ИУБГ-т хүргүүлсэн. Цахим хуудаст байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалттай танилцаад хүсэлт, гомдол гаргасан иргэний гомдлыг бүрэн шийдвэрлэж бүртгэл хөтлөн ажилласан. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогсоохтой холбоотой шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хуулийн хугацаанд нь бүртгэн баталгаажуулж, нотлох баримтыг бүрэн цахимжуулж илтгэх хуудсыг ИУБГ-т хүргүүлсэн. Сонгогчдын нэрийн жагсаалтад нэмэлт тэмдэглэгээ хийсэн иргэдийн мэдээллийг нягтлан шалгаж гадаадад 60 ба түүнээс дээш хугацаагаар зорчсон гэх түр хасав төлөвтэй оноосон иргэдээс 195 иргэн зорчоод ирсэн тухай хүсэлт ирүүлсний дагуу түр хасав төвлийг сэргээсэн. Сонгуулийн хэсэгт ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудын судалгааг гарган Тагнуулын хэлтэст хүргүүлэн тагнуулын байгууллагын саналыг үндэслэн гэрээ байгуулж, нууцын баталгаа гаргуулан эрх зүйн сургалт зохион байгуулан итгэмжлэгдсэн ажилтнуудыг арга зүйгээр ханган ажилласан. Сонгогчдийн нэрийн жагсаалт хэвлэх бэлтгэл ажлыг ханган хуулийн хугацаанд хэсгийн хороодод хүргүүлсэн. Сонгуулийн санал авах өдөр Булган аймгийн хэмжээнд 70 хэсэг дээр 71 итгэмжлэгдсэн ажилтнууд 07:00 цагт ирц бүртгэлийн программыг нээж бүх хэсгүүд нээлтийн тайлан хэвлэж зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгсөн сонгогчдын бүртгэлийн хуудсыг хэвлэж хэсгийн хорооны даргад хүлээлгэн өгсөн. Санал авах өдөр тоног төхөөрөмжтэй холбоотой ямар нэгэн асуудал гараагүй ба иргэдээс гомдол санал ирээгүй болно. Тоног төхөөрөмж, нэрсийн жагсаалт, бүртгэлийн хуудас, тайлангуудыг итгэмжлэгдсэн ажилтнуудаас хүлээн авч нэгтгэн хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архив хүлээлгэн өглөө. АНСДИТХ-ын 2024 оны ээлжит сонгуулиар тус хэлтсийн хэрэгжүүлэх дэд төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний дагуу Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 13-р зүйлд заасны дагуу Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хэсэг, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг тогтоосон тогтоолуудыг хүлээн авч нягтлан шалгаж сонгогчийн бүртгэлийн програмд шивж баталгаажуулан хэсэг байгуулсан тогтоолуудыг нэгтгэн УБЕГ-т хуулийн хугацаанд нь хүргүүлсэн. Сонгуулийн санал авах байрны дэргэд ажиллах



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

76 хэсгийн 76 итгэмжлэгдсэн ажилтнуудад эрх зүй болон тоног төхөөрөмжийн сургалтыг зохион байгуулж мэргэжил арга зүйгээр тогтмол ханган ажилласан. Цахим хуудсанд байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалттай танилцаж зөрүүтэй гэж мэдээлсэн 6 иргэний хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж ажилласан. Сонгуулийн санал авах өдөр ямар нэгэн алдаа зөрчил, гомдол санал гараагүй болно. Сонгогчдын нэрийн жагсаалт, бүртгэлийн хуудас зэрэг баримт материалуудыг итгэмжлэгдсэн ажилтнуудаас акт үйлдэн хүлээн авч архивын хадгаламжийн нэгж үүсгэн байгууллагын архивт хүлээлгэн өгсөн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.



Сонгуулийн тухай хуулийн дагуу иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогссонтой холбогдуулан шилжин ирсэн иргэдийн тоон мэдээг өмнөх онуудын мөн үетэй харьцуулан видео мэдээ бэлтгэн хэлтсийн цахим хуудас болон пэйсбүүк, пэйж хуудаст байршууллаа. Мөн сонгуулийн тухай хуулийн дагуу цахим хуудаст байршуулсан сонгогчдын нэрийн жагсаалттай хэрхэн танилцах талаар видео контент бэлтгэн хэлтсийн цахим хуудас болон пэйсбүүк, пэйж хуудаст байршуулсан.

Сургалт, сурталчилгааны чиглэлээр :

Иргэний улсын бүртгэгч нарт ИУБГ-аас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг танилцуулах, мэргэжил арга зүйгээр хангах, бүртгэлийн алдаа зөрчилөөс урьдчилан сэргийлэх үүднээс 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 19 удаагийн цахим



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

хурал, 1 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж дараах арга хэмжээг авч ажилласан.

- ИУБГ-ын 2024.04.15-ны 3/4861 тоот албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн хүрээнд: Иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд иргэний эцэг/эх/-ийн нэр болон өөрийн нэрийн үсгийн латин хөрвүүлэг буруу байгаагаас иргэнд зөрчилтэй гадаад паспорт олгох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2024.01.01-6.01-ны хооронд төрөлтийн бүртгэлд бүртгэсэн 308 хүүхдийн овог, нэрийн латин хөрвүүлгийг мэдээллийн санд шалгахад 4 хүүхдийн нэрийн галиг буруу сонгосон зөрчил илэрсэн бөгөөд улсын бүртгэгч нарт дахин анхааруулж ажиллалаа. Дээрх 4 иргэний нэрийн галигийг засуулж зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч галигыг засуулсан.

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын даргын ирүүлсэн 2024.06.07-ны 3/7822 тоот албан бичгийн хавсралтаар ирүүлсэн Хяналтын улсын ахлах байцаагч А.Мөнхцэцэгийн 2024.06.04-ны өдрийн 22 дугаартай мэдэгдлийг 2024.06.05-ны өдөр хүлээн авч 2024.06.06-ны өдрийн 10⁰⁰ минутад цахим хурал зарлаж 16 сум 1 тосгоны Улсын бүртгэгч нарыг 100% хамруулан, хэлтсийн албан хаагчдад танхимаар дээрх албан бичиг болон хавсралтаар ирүүлсэн мэдэгдлийг танилцуулж цаашид өдөр тутмын ажил үйлчилгээнд тогтмол хурууны хээгээр үйлчилгээ үзүүлж байхыг анхааруулж, аливаа эрсдэл, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээллийг хүргэсэн.

**1.6. Хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:
НЭГ. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАЛААР:**

Тасаг нь өнөөдрийн байдлаар тасгийн дарга, эд хөрөнгийн 2 улсын бүртгэгч, суманд эрхзүйч мэргэжилтэй эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл хийх эрх авсан 8 сумын улсын бүртгэгчтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Дээрх сумдад хуулийн этгээд, эд хөрөнгийн бүртгэл хийх эрх авсантай холбоотойгоор 5 дугаар сарын 19, 20-ны өдөр улсын бүртгэгч нарыг дуудаж эд хөрөнгийн ерэгс мэдээлийн сан, хуулийн этгээдийн ерс санд нэврэх эрх авч мэдээллийн санд ажиллах бүртгэлийн дадлага ажлыг амжилттай хийж сургасан.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 сарын 15-ны өдрийн Б/165 дугаар тушаалаар хуулийн этгээдийн улсын бүртгэгч А.Раднаабаяр Иргэний улсын бүртгэлийн тасгийн Рашаант сумын иргэний улсын бүртгэгчээр томилогдсон. Тасгийн дарга бөгөөд ахлах улсын бүртгэгч Л.Байгалмаа нь мөн өдрөөс хуулийн этгээдийн бүртгэлийг хавсран гүйцэтгэж байна. Л.Байгалмаа нь хуулийн этгээдийн ерс мэдээллийн санд ажиллах болон хууль эрхзүйн дадлага ажлыг Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хуулийн этгээдийн бүртгэгч М.Цогтбаатараар заалгаж дадлагажсан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэгчийг хэлтсийн даргын 3 дугаар сарын 18-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар хяналтын улсын байцаагч, ИУБТасгийн дарга, архивч, мэдээлэл



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

технологийн ажилтан гэсэн бүрэлдэхүүнтэй хүлээн авч хуулийн этгээдийн бүртгэгчийн мэдээллийн санд дутуу орхисон нийт 201 бүртгэлийг жагсаалтаар тулган хүлээн авч ажиллалаа. Эдгээр 201 бүртгэлийг шалгахад бүртгэл дууссан дамжлагаар 107, цахимжуулалт-71, мета дата төлөвтэй 23 бүртгэл байсан. Үүнийг он сараар нь ялгаж харахад бүртгэл дуусан 107 бүртгэлээс 2021 оны 27 бүртгэл, 2022 оны 2, 2023 оны 35, 2024 оны 42 бүртгэл байсан. Цахимжуулалт төлөвтэй 71 бүртгэлийг үзэхэд 2022 оны 1, 2023 оны 34, 2024 оны 36 бүртгэл байсан. Мета дата төлөвтэй 23 бүртгэлийг үзэхэд 2021 оны 2 бүртгэл, 2023 оны 13, 2024 оны 11 бүртгэл байсан. Ажлын хэсэг дээр эд хөрөнгийн бүртгэгч Н.Билгүүн, жолооч Б.Ганбаяр нарын нэмж авч 3 сарын 28 ,29-ны өдөр ажлын бус цагаар сууж шөнийн 01, 02 цаг хүртэл хоёр өдөр сууж цахимжуулж архивт шилжүүлсэн.

1 сарын 02-ны өдрөөс 11 сарын 20-ны өдрийн байдлаар нийт шинээр 568 хуулийн этгээд шинээр бүртгэгдсэн байна.

- Хоршоо-481
- ХХК-73
- Холбоо/НҮТББ/-5
- Холбоо/ГҮТББ/-2
- Төрийн байгууллага-2
- Үйлдвэрчний эвлэлийн холбоо-1
- Нөхөрлөл /ЗБН/-2

Сумын нэр	Улсын бүртгэгчийн нэр	Шинэ бүртгэл	Мэдээлэлд оруулсан өөрчлөлт тийн бүртгэл	Нэрийн баталгаа-жуулалт	Тамга тэмдгийн хяналтын дугаар			Лавлагаа
					Шинэ	Дахин	Хураал-гасан	
Булган	А.Раднаабаяр	34	54	59	40	16	11	
	Л.Байгалмаа	236	181	67	238	27	17	10
Баян-Агт	Ж.Байгалмаа	31	13	14	31	1	1	
Баяннуур	Н.Бүрэндүүрэн	83	15	14	84	0	0	1
Бугат	Ш.Лхагвасүрэн	9	2	16	9	0	0	
Бүрэгхангай	Г.Ганчимэг	25	9	9	25	0	0	
Гурванбулаг	С.Энхтуяа	46	8	13	47	2	2	
Орхон	Д.Сувд-Эрдэнэ	28	15	2	28	1	0	
Сэлэнгэ	Б.Золжаргал	21	10	2	21	1	0	
Хишиг-Өндөр	Б.Сувдаа	50	1	2	49	0	0	
НИЙТ		563	308	198	572	48	31	11

ХОЁР. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТАЛААР:

Хэлтсийн даргаар 3 дугаар сарын 01-ны өдөр эд хөрөнгийн бүртгэгч нарын ажил үйлчилгээний хуваарийг батлуулж улсын бүртгэгч Б.Одончимэгт Баян-Агт, Бүрэгхангай, Орхон, Дашинчилэн, Хялганат, Рашаант, Могод, Булган сумын 1,3,5 дугаар баг, улсын бүртгэгч Н.Билгүүнд Баяннуур, Бугат, Гурванбулаг, Хутаг-Өндөр, Тэшиг, Сэлэнгэ, Хангал, Сайхан, Булган сумын 2,4,6 дугаар багийг хариуцуулж бүртгэл хийлгэж байна. Эд хөрөнгийн нийт 5504 бүртгэл бүртгэгдсэнээс газрын 2331 бүртгэл, үл хөдлөхийн 3173



**БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

бүртгэл хийгдсэн байна. Үйлчилгээний хураамж 63.793.987төг, Тэмдэгтийн хураамж 4.806.382төг, татварын орлого-286.817.949төг орсон байна.

Нийт бүртгэлийг улсын бүртгэгч нараар нь гаргаж үзвэл:

СУМЫН НЭР	Улсын бүртгэгчийн нэр	Анхны бүртгэл		Өмчлөх эрх шилжих гэрээ	Барьцаа- ны гэрээ	Бусад гэрээ	Бүртгэлд өөрчлөлт оруулах	Хуул- бар	НИЙТ
		Газар	Үл хөдлөх						
Булган	Л.Байгалмаа	103	67	147	463	3	46	26	855
	Э.Нандинцэцэг	30	28	70	149	0	30	3	310
	Н.Билгүүн	190	127	355	1121	2	86	34	1915
	Б.Одончимэг	97	152	308	1011	2	52	69	1691
Баян-Агт	Ж.Байгалмаа	9	9	2	36	0	3	0	59
Баяннуур	Н.Бүрэндүүрэн	32	18	31	231	0	13	0	325
Бугат	Ш.Лхагвасүрэн	6	28	24	17	0	0	0	75
Бүрэгхангай	Г.Ганчимэг	0	5	3	20	0	2	0	30
Гурванбулаг	С.Энхтуяа	11	12	10	46	0	8	0	87
Орхон	Д.Сувд-Эрдэнэ	0	0	0	4	0	0	0	4
Сэлэнгэ	Б.Золжаргал	0	0	0	10	0	0	0	10
Хишиг- Өндөр	Б.Сувдаа	15	10	22	66	0	10	0	123
НИЙТ		493	456	972	3174	7	250	132	5484

Мөн тасгийн самбарын мэдээллийг шинэчилж сүүлийн 11 жилийн тоон мэдээг гаргаж тавьлаа. 11 сарын 20-ны байдлаар 2024 оныг нэмж 10 жилээр нь харьцуулж гаргав.

Үзүүлэлт	2015о н	2016о н	2017о н	2018о н	2019о н	2020о н	2021о н	2022о н	2023о н	2024о н
НИЙТ БҮРТГЭЛ	4217	4460	4177	4687	5028	5633	5034	3723	4504	5482
1 Анхны бүртгэл	1231	809	866	1205	859	864	715	879	760	827
Газар	847	511	565	795	540	559	343	569	475	481
Газраас бусад ҮХЭХ	462	258	282	363	319	305	372	310	285	346
Газар эзэмших	21	40	19	48	1261	1606	1200	1542	3453	
2 Өмчлөх эрх шилжих гэрээ	2016	2415	2256	3012	2479	2704	749	810	938	970
Худалдах- худалдан авах гэрээ	139	117	133	216	249	351	465	492	547	660
Бэлэглэх гэрээ	132	94	114	147	96	112	125	140	160	113
Өв залгамжлал өөрчлөгдөх	64	56	44	78	67	65	92	107	103	107
Хамтран өмчлөгч өөрчлөгдөх	123	81	73	101	64	52	67	69	121	59



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ШШӨ Өөрчлөгдөх	1	3	4	7	2		1	2	5	1
3 Барьцаан ы гэрээ	1557	2067	1876	2463	2008	2123	3145	1608	2272	3179
Ипотек буюу үл хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ	1021	1153	967	1386	1081	1154	1812	789	1259	1753
Барьцаа чөлөөлөх	536	914	864	1077	927	969	1333	819	1013	1426
4 Бүртгэлд өөрчлөлт оруулах	196	182	191	182	126	132	281	345	442	101
Хаяг өөрчлөгдөх	101	137	135	111	110	110	196	256	340	149

Эд хөрөнгийн лавлагааг хариуцсан сум, багийн үл хөдлөх хөрөнгөд гаргаж өгч байгаа нийт 11 сарын 20-ны өдрийн байдлаар 272 лавлагаа иргэн, хуулийн этгээдэд мэдүүлэгээр олгосон байна. Үүнээс

№	Лавлагаа гаргасан албан хаагч	лавлагааны тоо
1	Л.Байгалмаа	24
2	Э.Нандинцэцэг	2
3	Н.Билгүүн	96
4	Б.Одончимэг	89
5	Бугат сумын улсын бүртгэгч Ш.Лхагвасүрэн	15
6	Баяннуур сумын улсын бүртгэгч Н.Бүрэндүүрэн	14
7	Бүрэгхангай сумын улсын бүртгэгч Г.Ганчимэг	18
8	Гурванбулаг сумын улсын бүртгэгч С.Энхтуяа	18
9	Хишиг-Өндөр сумын улсын бүртгэгч Б.Сувдаа	12
Нийт лавлагааны тоо		272

Ахлах бүртгэгчийн зүгээс хуулийн хяналтын байгууллагын лавлагааг гаргасан бөгөөд 68 албан бичгээр 55 лавлагааг гаргаж, хугацаатай албан бичгийг хуулийн хугацаанд нь гаргаж ажилласан байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулинд 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Эрхийн улсын бүртгэлд тусгах үл хөдлөх хөрөнгийн үнийн талаар өөрчлөлт орж урьд өмнө мэдүүлэг гаргагчийн тодорхойлсон үнээр бүртгэдэг байсан бол батлагдсан төсөвт өртөгөөр тодорхойлсон үнээр бүртгэхээр заасныг тухайн барилгын төсөвт өртөгийг өмчлөгчөөр бичүүлж үл хөдлөх хөрөнгийг анх удаа бүртгэж байна. Мөн хуулийн 9.1.4-т Газрын эрх, үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах тохиолдолд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн барьцааны гэрээ эсхүл барьцаалбарт тусгагдсан тухайн эд хөрөнгийн барьцааны үнэ гэж заасан байна. Уг заалт мөн 9.3-т заасан улсын бүртгэлд бүртгэлтэй үнээс бууруулж бүртгэхгүй гэж заасныг Булган аймагт үйл ажиллагаа явуулж тойргийн нотариат, банк, банк бус байгууллагуудтай нэгдсэн ойлголтод хүрэхийн тулд Хаан банк, Төрийн банк, Хас банк, Нэткапитал ББСБ, Сэндли ББСБ, 2 тойргийн нотариаттай биечлэн уулзаж тайлбарлаж, албан бичиг өгч ажиллалаа.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



1.7. Санхүүгийн чиглэлээр:

2024 жилийн эцсийн байдлаар улсын төсвөөс үйл ажиллагааны санхүүжилтэд 1224227,0 мянган төгрөг авч, сар бүрийн төсвийн хуваарийн дагуу төсвийн урсгал зардалд 1028699,3 мянган төгрөгийн зардал гаргаж, улсын бүртгэлийн үйлчилгээний орлогоор 116344,7 мянган төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Орон нутгийн төсвөөс төрийн захиргааны албан хаагчдын орон нутгийн нэмэгдэл цалинд 40392,5 төгрөгийн санхүүжилт авч 40392,5 төгрөгийг олгосон. УИХ болон орон нутгийн ээлжит сонгуулийн зардалд 82423,5 мянган төгрөгийн санхүүжилт зарцуулсан.

Төсвийн зарлагыг төсвийн зүйл анги, зардлын төрлөөр харуулбал:

№	Зардлын нэр төрөл	Төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт	
				Тоо хэмжээ	хувь
1	Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал	860779,3	851094,0	9685,3	94.8
2	Нийгмийн даатгалын шимтгэл	100854,9	92811,0	8043.9	92.0
3	Байр ашиглалтын зардал	44600,0	28603	15997.0	64.1
	Гэрэл цахилгаан	6600,0	2165,6	4434.4	32.8
	Түлш халаалт	32500,0	24818,1	7681.9	76.3
	Цэвэр, бохир ус	5500,0	1619,3	3880.7	29.4
4	Хангамж. Бараа материалын зардал	11948,6	11638.5	310.1	97.4
	Бичиг хэрэг	7040,0	7040,0	0	
	Тээвэр шатахуун	1466,3	1466,3	0	
	Шуудан холбоо	1536,0	1232,3	303.7	80.2
	Хог хаягдал	146,3	139,9	6.4	95.6
	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	1760,0	1760,0	0	
5	Эд хогшил, урсгал засварын зардал	9078,9	9078,9	0	
	Багаж, техник хэрэгсэл	3760,0	3760,0	0	
	Хөдөлмөр хамгааллын зардал	586,3	586,3	0	
	Урсгал засвар	4586,3	4586,3	0	



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

6	Томилолт	146,3	146,3	0	
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	1557,6	1186,0	371.6	76,1
	Бусад нийтлэг АҮТХ	1466,3	1186,0	280.3	80.8
	Тээврийн хэрэгслийн татвар	91,3		91.3	
8	Хичээл үйлдвэрлэлийн зардал	880,0	880,0	0	
10	Нэг удаагийн тэтгэмж	550,0	550,0	0	0
	Дүн	1030395,6	995987.7	34407.9	96.6

Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 5 жилийн тэтгэмж 127465,7 мянган төгрөг. Тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж 67500,0 мянган төгрөг, Нэг Удаагийн төгрөг 300,0 төгрөг зарцуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлээс харахад 11 сарын байдлаар хэтэрсэн зардал байхгүй, ашиглалтийн зардал 35,9 хувийн, хангамжийн зардал 2,6 хувийн, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 23,9 хувийн, Бусад нийтлэг АҮТХ 19,2 хувийн хэмнэлттэй нийт зардал 3,4 хувийн хэмнэлттэй байна.

Төсвийн гүйцэтгэл, мөнгөн хөрөнгө, ер авлага, үйлчилгээний орлогын мэдээг сар бүрийн 2-нд гаргаж, УБЕГ-ын санхүүгийн хэлтэст болон төрийн санд гаргаж өгч, шилэн дансанд 132 төрлийн мэдээ мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан. 2024 оны 1-3-р улирлын тайлан мэдээг хугацаанд нь гарган, ерөнхий газрын санхүүд нэгтгүүлсэн. Бараа материалын болон үнэт цаасны тайланг сар бүр гарган, үнэт цаасны тайланг сар бүрийн 5-ны дотор ерөнхий газрын санхүүд нэгтгүүлэн тооцоог хийсэн. Үйлчилгээний орлогын тооцоог хийж сар бүрийн эцэст улсын төсөвт төвлөрүүлж ажилласан байна.

1.8. Архивын үйл ажиллагааны чиглэлээр:

Тус хэлтсийн архивт 2024 оны жилийн эцсийн байдлаар иргэний бүртгэлийн 72722 ,ЭХЭУБ-ийн 20043, ХЭУБ-ийн 2132 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Иргэний бүртгэлийн архивын чиглэлээр:

Нийт 72722 хувийн хэрэг хадгалагдаж байгаагаас хүүхдийн санд – 13171 хүүхдийн хувийн хэрэг, хувийн хэрэгжсэн санд-39803 нас баралтын санд-17933 хувийн хэрэг , тодорхой бус иргэдийн санд –499, он тодорхой бус нас баралтын санд-1316-ыг он дараалал болон цагаан толгойн галигийн дарааллын дагуу архивт байршуулсан байгаа болно.

Иргэний баримт бичгийн архивт иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн 8 төрөл, иргэний шинэчилсэн бүртгэлийн маягт-31,ИУДАӨ,шилжилт хөдөлгөөний ИУБ-22 төрлүүдээр нийт 642 иргэдийн хувийн хэргийг жилийн эцсийн байдлаар хүлээн авч архивт байршууллаа. Төрөл тус бүрээр нь авч үзвэл ИУБ-11 маягт 528,ИУБ-12 маягт 19, ИУБ-13 маягт 36, ИУБ-14 маягт 26, ИУБ-15 маягт 129, ИУБ-16 маягт 29 г, ИУБ-18 маягт 265, ИУБ-22 маягт – 816,ИУБ-31 маяг 616 , ИУДАӨ-124-г жагсаалтаар хүлээн авч архивт байршуулан ажиллаа.

Орон нутгийн улсын бүртгэгч нараас оны эхэнд өмнөх оны бүртгэлийн бүрдүүлбэр материалууд болон иргэний 8 төрлийн бүртгэлийн журналуудыг



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

жагсаалтаар хүлээн авч Улсын ахлах бүртгэгчээр хянуулан архивт хүлээн авч байршуулах ажил тогтмол хийгдэн явагдаж байна.

Мөн энэ онд 16 нас хүрч шинээр иргэний үнэмлэх авах 490 хүүхдүүдийн хувийн хэргүүдийг хүүхдийн сангаас ялган салгаж тусад нь байршууллаа.

2023 онд хадгалах хугацаа дууссан 12406 хуудас бүхий 73 хадгаламжийн нэгж, 922 хуудас бүхий 20ш бүртгэлийн дэвтэр, 523ш ИУБ маягтуудын жагсаалтыг гарган устгалд оруулах саналыг 2023 оны 11 сарын 31 нд жагсаалтаар хүргүүлж устгах зөвшөөрөл ирсэний дагуу хэлтсийн даргын 2024 оны а/05 тоот тушаалаар комисс томилогдож устгах ажиллагааг 2024.01.11 ны өдөр явуулж, тайланг УБЕГ-т хүргүүлж ажиллаа.



Иргэний 8 төрлийн бүртгэлээр болон ААН байгууллагад лавлагаа олгоход шаардлагатай архивын эх нотлох баримт болон журналыг лавлагаа хариуцсан улсын бүртгэгчид, ямар нэгэн зөрчилтэй ХУБ-дээр шалгагдах шаардлагатай иргэдийн хувийн хэрэг болон бусад шаардлагатай материалуудыг тухай бүрт нь гарган өгч ажиллаа.

ЭХЭУБ-ийн архивын чиглэлээр:

ЭХЭУБ-ийн архивт нийт 20043 хувийн хэрэг хадгалагдаж байгаагаас газраас бусад үл хөдлөх хөрөнгийн бүртгэл 9101, газрын бүртгэл 10942, хадгалагдаж байгааг сум тус бүрээр газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлээр ангилан архивт байршуулсан байгаа болно.

Энэ оны жилийн эцсийн байдлаар ЭХЭУБ-ийн архивт газраас бусад эд хөрөнгийн хувийн хэрэг 378, газрын хувийн хэрэг 421 шинээр бүртгэгдсэнг архивт журналаар хүлээн авч хавтаслан сум тус бүрээр шинээр хувийн хэрэг үүсгэн дугаарын дагуу байршуулж, нэмэлт үйлчилгээ хийгдсэн материалуудыг тухай бүрт нь мөн журналаар хүлээн авч архивын баяжилтанд байршуулан ажилласан.

Хуулийн этгээдийн бүртгэлийн архивын чиглэлээр:



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Тус тасгийн архивт оны эхний байдлаар 1636 аж ахуйн нэгжийн хувийн хэрэг байршиж байснаас шинээр 504, шилжин явсан 11, шилжин ирсэн 3 бүртгэл хийгдэж одоогийн байдлаар 2132 аж ахуйн нэгжийн хувийн хэрэг байршиж байна.

Цахимжилтанд ороогүй байсан 200 гаран хувийн хэргийг архиваас татан авч жагсаалтаар тасгийн ахлах улсын бүртгэгчид хүлээлгэн өгч цахимжуулан буцаан архивт жагсаалтын дагуу хүлээн авч байршуулах, мөн баяжилтанд ороогүй байсан 126 аж ахуйн нэгжийн нэмэлт материалыг архивт баяжилтанд оруулж ажиллаа. Аймгийн сум дундын шүүхээс маргаантай хуулийн этгээдийн хувийн хэргүүдэд үзлэг, шалгалт хийх үед холбогдох материалыг гарган өгч шаардлагатайг нь канондаж “ХУУЛБАР ҮНЭН” тэмдгээр баталгаажуулан хууль журмын дагуу гаргаж өгч ажиллаж байна.

Архивын байрны галын буланг сэргээн “Гамшиг ослын үед архивын байрнаас баримт материалыг зөөвөрлөх хуваарийг хэлтсийн даргын тушаалаар томилуулан, хэлтсийн байранд гамшиг осол гарсан үед хийх дадлага сургуулийг нэг удаа зохион байгуулан галын буланд дутуу байсан хүрз-2ш, галын цохиур, тармуур зэргийг шинээр нэмж байршуулсан.



1.9. Мэдээлэл технологийн чиглэлээр:

Булган аймгийн УБХ-ийн тоног төхөөрөмжийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор дотоод сүлжээ, интернэт сүлжээ, бүх албан хаагч, сумдын улсын бүртгэгч нарын компьютер, принтер, хувилах төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанд байнгын бэлэн байдлыг ханган тухай бүрт нь засвар үйлчилгээ хийгдэж, шинээр солих шаардлагатай бол шинэчилж ажиллаж байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжид давхардсан тоогоор нийт 20 удаа засвар үйлчилгээг хийснээр одоо ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүд хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улсын бүртгэлийн ерөнхий газраас программ хангамж болон техник хангамжийн шинэчлэл, сайжруулалтын ажлыг байнга хийдэг бөгөөд “Улсын бүртгэлийн байгууллагын дэд бүтцийг хөгжүүлэх замаар иргэдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх төсөл”-ийн хүрээнд бүртгэлийн мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн шинэчлэл, анхан шатны нэгжүүдийн тоног төхөөрөмжийг бүрэн шинэчлэх зэрэг ажлуудыг тогтмол хийдэг.

БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар аймгийн 16 сум 1 тосгоны улсын бүртгэгч нарт компьютер 17 ширхэг, 3 үйлдэлт принтер 17 ширхэг, хурууны хээ уншигч 17 ширхэг, зургийн аппарат 17 ширхэг зэрэг тоног төхөөрөмжийг иж бүрэн шинэчилсэн бөгөөд тус бүрийн тоног төхөрөмжийн системийн хэвийн үйл ажиллагааг ханган программ хангамж зэргийг бүрэн суулган ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Хэлтсээс зохион байгуулсан үйл ажиллагаа болон УБЕГ-аас зохион байгуулсан мэдээ мэдээлэл, санхүү хүний нөөц, сар бүрийн тоон мэдээлэл, өргөдөл гомдлын мэдээлэл, имфографик мэдээлэл, видео мэдээ зэргийг цаг тухай бүрт нь www.bulgan.burtgel.gov.mn гэсэн цахим хуудаснаа нийтлэн иргэд олон нийтэд түгээн ажиллаж байна.



БУЛГАН АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

НҮҮР ХУУДАС ТАНИЛЦУУЛГА ИЛ ТОД БАЙДАЛ ХЭРЭГЛЭГЧ ТАНД ХОЛБОО БАРИХ Search...

ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

Шилжилт хөдөлгөөний бүртгэлийн талаар
2024-05-09

Тэрбум мод
2024-05-09

Шилжилт хөдөлгөөний бүртгэлийн талаар
2024-05-09

Та сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд

Бусад мэдээлэл →

ВИДЕО МЭДЭЭ

Шилжилт хөдөлгөөний бүртгэлийн талаар
2024-05-09

АТГ-т 2 15 ны дотор хөрөнгө, орлогоо мэдүүлэх
2023-01-12

Иргэний үнэмлэхийн хугацаа хүчин төгөлдөр байгаа тохиолдолд дахин захиалах шаардлагагүй

Бусад видео мэдээлэл →

БУЛГАН АЙМГИЙН ТУХАЙ

БНМАУ-ын Ардын сайд нарын Зөвлөлийн 1937 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийг Булган, Сэлэнгэ хоёр аймаг болгон тусгаарлан байгуулжээ.
Дэлгэрэнгүй →

Тайлант хугацаанд Булган аймгийн 16 сум, 1 тосгон, хэлтсийн хэмжээнд бүртгэлийн ерөнхий сүлжээ нь Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК-ын сүлжээгээр хангагдаж ажиллагаа бүрэн хэвийн ажиллаж байгаа бөгөөд доорх засвар үйлчилгээг хийж ажилласан.

2024 онд Баян-агт сумын рүүтер гэмтэж шатсанаас 1 сумын рүүтерийг шинээр сольсон.

Орхон сумын рүүтерийн залгуур шатсанг шинээр сольсон.

Сайхан сумын мэдиа конвертер шатсанг сольсон.

Хэлтсийн сүлжээний шилэн кабель тасарсанг цаг алдалгүй гагнаж сүлжээг хэвийн болгосон.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

8-н сум Эд хөрөнгө, Хуулийн этгээдийн эрх авсантай холбогдуулан амралтын өдрөөр сургалт хийн техник болон программ хангамжийг суулган ажиллалаа.

**ХОЁР. ОРОН НУТГИЙН УДИРДЛАГА, БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН
АЖИЛЛАХ ЧИГЛЭЛЭЭР:**

Булган аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс цахим төлбөрийн систем болох бүх төрлийн төлбөр төлөх Гэрэгэ киоск машиныг Гурванбулаг суманд байлуулахаар шийдвэрлүүлэн 2023 оны 05 дугаар сараас сумын ЗДТГ-т байршуулан үйлчилгээнд нэвтрүүлэн ажиллаж байна.



2024.03.28-нд Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах нэгдсэн дадлага сургуулилтад дүрмийн дагуу бэлэн байдлыг ханган оролцлоо



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан хэлтсийн эмэгтэй албан хаагчид гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцсон.



Улсын бүртгэлийн байгууллагад Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны дэмжлэгтэйгээр хэрэгжиж эхлээд буй “ТА10201-МОН: Сумдад эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах” төслийн нээлтийн семинарыг 2024.04-р сард зохион байгуулж тус аймгийн 8 сумын улсын бүртгэгч нарыг сургалтад хамруулж, удирдлага арга зүйгээр ханган, Булган аймгийн Баян-Агт, Баяннуур, Бугат, Бүрэгхангай, Гурванбулаг, Орхон, Сэлэнгэ, Хишиг-Өндөр сумдад эд хөрөнгө болон хуулийн этгээдийн бүртгэл үйлчилгээг сумын нутаг дэвсгэрт нь үзүүлж эхэлсэн байна.



“ЦЭВЭР ОРЧИН-ЦЭМЦГЭР
БУЛГАН” аяны хүрээнд 2 удаа
байгууллагын ойр орчмын
цэвэрлэгээ болон авто зам дагуух
хуваарьт цэвэрлэгээг хийж
гүйцэтгэлээ



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024.04.24-ны өдөр Цахим хөгжил харилцаа холбооны сайдын баталсан “Цахим аймаг” бодлогын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, орон нутагт цахим шилжилтийг эрчимжүүлэхэд тулгамдаж буй асуудлуудад мэргэжил арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх “Цахимд хэвшье” уриатай “Digital firstD1” арга хэмжээ зохион байгуулагдаж уг арга хэмжээнд хэлтсийн ажилтан Б.Ганбаяр сургалтад сууж, гэрэгэ киоск машины үйлчилгээг сурталчилан таниулах арга хэмжээнд хамтран ажилласан.



“Илүүдэл жингүй-Эртэч Булган” аянд хамт олноороо нэгдэж ажлын цагаас өмнө өглөөний алхалт, дасгал хөдөлгөөн, гимнастик хийж гүйцэтгэсэн.



2024.02.26-нд Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан “Бүртгэлийн илч” хандивын аянд Булган аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон нэгдэж 310,000 /гурван зуун арван мянга/ төгрөгийн хандивыг цуглуулан малчдад хүргэх арга хэмжээг зохион байгуулж, Бүртгэлийн байгууллагын түүхт 84 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буй “Хүүхдийн төлөө” аянд нэгдэж 270,000 /хоёр зуун далан мянга/ төгрөгийн хандив хүргүүлсэн.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024.05.01-ны өдөр Иргэдэд хууль зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй өгөх “Хуульчийн про боно өдөр-2024” өдөрлөгт улсын бүртгэлийн хэлтэс оролцож 28 иргэнд зөвлөгөө мэдээлэл хүргэж, бүртгэлийн үйлчилгээний талаар мэдээлэл танилцуулга тараан ажилласан.



Хүрч үйлчилье “НЭЭЛТТЭЙ ХААЛГА”-ны өдөрлөгийг тайлант хугацаанд 2 удаа зохион байгуулж иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтийг хүлээн авч ажилласан бөгөөд нийт давхардсан тоогоор 42 иргэнд бүртгэлийн талаарх зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан.

Иргэдээс ирүүлсэн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлтэд дүн шинжилгээ хийж үзэхэд талархал 3, бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой хүсэлт 2 ирсэн бөгөөд улсын бүртгэлийн байгууллагаар үйлчлүүлсэн сэтгэл ханамж ХАНГАЛТТАЙ, САЙН гэж дүгнэгдсэн байна.



Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжийг ашиглан ШШГЕГ-ын харъяа Хорих 439 дүгээр хаалттай хорих ангитай хамтран хүний эрхийг хангах зорилгоор 2024.04.30-ны өдөр тус хорих ангид ял эдэлж буй 6 хоригдолд иргэний үнэмлэхийн сунгалтын бүртгэл, 13 хоригдолд иргэний үнэмлэхийн дахин олголтын бүртгэл 2024.11.19-ны өдөр 7 хоригдолд иргэний үнэмлэхийн сунгалтын үйлчилгээг үзүүлж иргэний үнэмлэхийг олгон хамтарч ажиллалаа. Мөн 2024.10.03-ны өдөр тус хорих ангид ял эдэлж байгаа 1 хоригдлын гэрлэлтийг бүртгэж 2 иргэнд гэрлэлтийн



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

гэрчилгээ олгосон. 2024.06.04-ний өдөр Булган аймгийн ШШГГазарт хоригдож буй хоригдолд биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлж иргэний үнэмлэх олгосон



2024.11.22-нд Онцгой байдлын газартай хамтран Тархалтын нэгдсэн дадлага сургуулилд дүрмийн дагуу бэлэн байдлыг ханган оролцлоо

ГУРАВ. ИДЭВХ САНААЧИЛГА, ШИНЭЛЭГ АЖЛЫН ТАЛААР:

2024 оны 01 дүгээр сард хэлтсийн албан хаагчдад хамт олны уур амьсгалыг эерэг байлгах, улсын бүртгэлийн байгууллагын цаашид авч хэрэгжүүлэх ажил үйлчилгээг тодорхойлох зорилгоор “Инээмсэглэл-Өглөөний яриа” арга хэмжээг зохион байгуулсан.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



2024 оны 02 дугаар сарын хэлтсийн албан хаагчдад “ЭРҮҮЛ МЭНД БЭЛЭГЛЭЭ” аянг өрнүүлэн эмэгтэй албан хаагчдыг хиймэл оюун ухаанаар оношилгоо хийдэг “CERVICACRI AI” аппаратаар умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг оношилгоо, шинжилгээнд бүрэн хамруулсан. Мөн хэлтсийн албан хаагчдыг амны хөндийн эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж, шүдний эмчилгээ хийлгэх шаардлагатай албан хаагчдад эмчилгээний цагт нь зориулан шүдээ эмчлүүлэх зорилгоор ажлын чөлөө олгон ажиллалаа.



Тайлант хугацаанд авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн 1 контент бүтээж иргэд олон нийтэд цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулан сурталчилж ажилласан бөгөөд III, IV дүгээр улиралд багтаан дахин 1 контент бэлтгэх түгээхээр төлөвлөн ажиллаж байна.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Шилжилт хөдөлгөөний бүртгэлийн талаарх мэдээллийг болон сонгогчдын нэрсийн жагсаалтад өөрийн болон өөрийн хаягт бүртгэлтэй сонгогчдын мэдээлэлтэй танилцах талаар мэдээллийг хэлтсийн цахим хуудас болон пэйж хаягаар дамжуулан 2 контент бэлтгэн иргэд олон нийтэд хүргэж танилцуулсан.



2024 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс Булган аймгийн Булган сумын Засаг даргын тамгын газрын байранд “24/7 ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ”-ыг байгуулан байршуулж иргэдэд ойр төрийн үйлчилгээг үзүүлж байна.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Бүртгэлийн байгууллагын түүхт 84 жилийн ойн баярын хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдын дунд “Дартсын аварга” шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа.

ДӨРӨВ. “ТЭР БУМ МОД” ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй ТЭРБУМ мод үндэсний хөдөлгөөний хүрээнд хийгдсэн мод тарих үйл ажиллагаанд хэлтсийн албан хаагчид оролцож өмнөх онд тарьж ургуулсан модны ургалтыг шалган арчилж шинээр 60ш мод суулгаж, тарьлаа.



Тайлант хугацаанд мөн 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдөр шинээр дахин 60 ш мод суулган тарьж, хавар тарьсан модоо арчилж ажилласан байна.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



ТАВ. “МОНГОЛ БИЧГИЙН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР”-ИЙН ХҮРЭЭНД:

Булган аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь 2022 онд Үндэсний хос бичигтэн болох аянд нэгдэж Булган аймгийн Ерөнхий боловсролын “Эрдмийн өргөө” цогцолбор сургуулийн монгол хэл, уран зохиолын багш Д.Гүнсмаагаар анхан шатны 20 цагийн хичээлийг заалган албан хаагчыг бүрэн хамруулж анхан шатны мэдлэгийг эзэмшсэн. 2024 оны 08 дугаар сард Булган аймгийн Боловсрол соёлын газрын харьяа насан туршийн боловсролын мэргэжилтэн М.Дэлгэрмаагаар дунд шатны мэдлэг олгох сургалтыг авахаар төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

/2022 оны анхан шатны сургалтын фото зураг хавсаргав/



Булган аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь байгууллагынхаа хаяг, албан хаагчдын ажлын хавтас, өрөө тасалгааны танилцуулга, самбарын мэдээллийг Монгол бичгээр хөтлөн үйл ажиллагаандаа ашиглаж хэвшээд байна.




БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

"МОНЦАМЭ" агентлагаас эрхлэн гаргадаг "Хүмүүн бичиг" сониныг бүх албан хаагчид захиалан уншиж, Үндэсний бичгээр бичигдсэн "Оюуны мэлмий", "Тод мөр", "Таван Эрдэнэ" ном, бусад гарын авлагыг нэгтгэн Монгол бичгийн **БУЛАНГ** ажиллуулан сурах орчин нөхцөлийг бүрдүүлсэн. "Их монгол толь", "Тайлбар толь", "Chimee" аппликейшныг гар утсандаа суулган хэрэглэж, албан хаагчдын компьютерт **Cms ulaanbaatar, Mongolian bati, Huree** зэрэг үсгийн фонд, суулган цахим бичвэр бичихэд суралцаж байна.



2024.04 дүгээр сард хэлтсийн бүх албан хаагчдыг "Төрийн албан хаагчийн үндэсний мэдлэгийн тодорхойлох судалгаа"-нд бүрэн хамруулсан.

2024.05.03-ны өдөр "Үндэсний Бичиг соёл номын өдрүүд"-ийн хүрээнд зохион байгуулж буй "Бидний бичиг соёл" уралдааны "Хурдан уншлага"-ын уралдаанд Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон амжилттай оролцсон.



БУЛГАН АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024 оны 10 дугаар сард “Номтой нөхөрлөө” аяныг зохион байгуулж Булган аймгийн Төв номын сангаас зөөврийн номын сан хүрэлцэн ирж хэлтсийн албан хаагчдад карт нээлгэн, гэрээр ном уншиж үйлчүүлсэн бөгөөд аяны хүрээнд үндэсний бичгийн ном уншиж судлахаар үндэсний бичвэр бүхий номыг авч өдөр бүр дамжуулан уншиж байна.

